

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ



Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн
Сургалтын албаны дарга

ULZIISAIKHAN B.

Director, Study Board at Bilig Institute, University of Humanities

Товч агуулга: Шүүхийн захиргааны үйл ажиллагааны зарчим, үндсэн ойлголт, түүний хэрэгжилтийг шүүхийн захиргааны талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд авч үзлээ.

Abstract: The principles, general characteristics, realization of court administrative activities have been examined in the frame of Constitutional concepts.

I. ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ

Зарчим¹ (латин. principium) гэдэг үг нь ойлголт нь эхлэл, анхдагч, удирдлага болгох санаа, ямар нэгэн үйл явцын анхны байдал зэргийг ойлгоно.

Засаг төрөөс үйл ажиллагаандаа удирдлага болгон баримталдаг гол үзэл, журмуудыг зарчим гэнэ.² Энэ нь Үндсэн хуулийн үзэл санааг хэрхэн ойлгож нийтийн эрх зүйн ухамсарт нийцсэн хууль эрхийн актыг хэрхэн боловсруулах нь нээлттэй боловч үндсэн эхлэл гэдэг холбоо үгийн язгуур чанарт үнэлэлт өгөх арга зүйгээр тодорхойлвол зүйтэй болов уу. Судлаачид зарчмыг удирдан чиглүүлж буй үндсэн шинжээр нь хууль зүйн, ёс суртахууны, заншил (аливаа ард түмний заншлыг түүний эрхэмлэн шүтдэг зүйлсээс нь ангид ойлгож болохгүй, учир нь тэр бүгд нэг зарчимд тулгуурлаж, өөр хоорондоо

амин холбоотой байдаг юм³)-ын зарчим гэж зааглан судалж байна.

Нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг хангаж, түүний харилцааг зохицуулахад баримтлах хууль зүйн үндсэн чиглэмжийг эрх зүйн зарчим⁴ гэнэ.⁵

Эрх зүйт ёсны зарчмуудын тоонд хуулийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны зарчим, ерөнхий болон хийсвэр дүрэм журам бие даасан шүүхийн шударга процесс зэрэг багтана. Эдгээр дүрэм журмын гол зорилго бол хувь хүний эрх чөлөөг төрөөс хамгаалах явдал.⁶

Эрх зүйн зарчим нь эрх зүйн хамгийн гол шинж чиглэлийг илэрхийлж харуулсан үзэл санааны цогц мөн.⁷

Эрх зүйн ерөнхий зарчим – эрх зүйн мөн чанар, онцлог, агуулгыг бүхэлд нь илэрхийлж, эрх зүйн үндэсний

¹ Зарчим (нэр) гэж ямар нэгэн онол сургаал, шинжлэх ухаан, хууль, журам, заншлын үндсэн зүй ёс, гол баримтлал. Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. Мон судар хэвлэлийн газар. УБ., 2011. 551 дэх тал.

Зарчим. Удирдлага болгох санаа дагаж мөрдөх үндсэн дүрэм, эх үндэс юм. Үйл ажлын зарчим буюу максим гэгч нь нийгэм дэх хүмүүсийн харилцааг тодорхойлж буй ёс зүйн хэм хэмжээ юм. Ред Ц.Балхаажав. Философийн толь. УБ., 1990. 165 дахь тал.

Зарчим гэдэг бол үйл ажиллагаандаа удирдлага болгодог үндсэн эхлэл. Түүнийг хэр авч явах нь үе үеийнхний мэргэн оюун, мэрийлт чармайлтаас үлэмжхэн шалтгаална. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002. 130 дахь тал.

² Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 84 дэх тал.

³ Жан Жак Руссо. Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. Орч Р.Янжмаа. УБ., 2015. 173 дахь тал.

⁴ Эрх зүйн зарчим (англ. legal principle; ор. правовой принцип) – эрх зүйн иж бүрэн номлол буюу төсөөлөл, баримтлал, зан үйлийн ерөнхий суурь зарчим. Эрх зүйн зарчим нь эрх зүйн тодорхой журмаас иш татсан тухайн журмын гаргасан нийтлэг үндэслэлийг тодорхойлсон заалт. С.Нарангэрэл., Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2011. 663 дахь тал.

⁵ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 66 дахь тал

⁶ Н.Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ., 2007. 94 дэх тал.

⁷ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010. 112 дахь тал.



тогтолцоог удирдлага болгодог хамгийн гол, нийтлэг үзэл санаа юм.

Нэг. Эрх зүйн ерөнхий зарчим нь жам ёсны эрх зүйн ойлголт бөгөөд хүний бүтээсэн буюу позитив эрх зүйн хууль, журмын үр дүнг шалгах арга хэрэгсэл мөн.

Хоёр. Эрх зүйн ерөнхий зарчим нь олон улсын гэрээ, заншлын эрх зүйгээс хүчин чадлын хувьд сул бөгөөд зөвхөн талууд хоорондоо хэлэлцэн тохиролцсон үед л хэрэгждэг. Позитивист онолын хувьд ийнхүү тодорхойлдог байна.

НҮБ-ын Олон улсын шүүхийн дүрмийн 38 дугаар зүйлд уг шүүхийн хэрэглэх эрх зүйн эх сурвалжид “иргэншсэн улсуудад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн зарчим” багтахаар тусгасан байдаг нь олон улсын эрх зүйд үүсч болзошгүй энэхүү бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх зорилготой байна. Монгол Улсын Дээд шүүхээс 2008 онд “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дугаар тогтоолыг батлан гаргасан боловч Монгол Улсын Засгийн газар, түүний дотор Гадаад харилцааны яам болон Хууль зүйн яам нь Монгол Улсын нэгдэн орсон буюу соёрхон баталсан олон улсын баримт бичиг, гэрээ конвенцийн албан ёсны орчуулгыг хэвлэн нийтэлж баталгаажуулаагүйгээс шүүх тухайн гэрээ конвенцийн албан бус орчуулгад тулгуурлан хэрэг хянан шийдвэрлэх боломжгүй байна. Иймд Гадаад харилцааны яам, Хууль зүйн яамнаас ойрын хугацаанд Монгол Улсын олон улсын гэрээнд мониторинг хийж, тэдгээрийн орчуулгыг албан ёсоор баталгаажуулж, эрх зүйн эх сурвалжийн хувьд хүлээн зөвшөөрөх учиртай.

Ихэнх судлаач эрх зүйн ерөнхий зарчим гэдэг нь эрх зүйн бие даасан эх сурвалж мөн боловч түүний хэрэглэх хүрээ нь хязгаарлагдмал байдаг гэдэгтэй санал нийлдэг байна. Эрх мэдлийн хуваарилалтын улс төрийн зарчмын

нөлөөгөөр үндсэн хууль тогтоогч нь хууль тогтоох үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл эрх зүйн ерөнхий хэм хэмжээг тогтоох үйл ажиллагааг, мөн шүүх эрх мэдэл ба засаг захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор төрөл бүрийн байгууллага байгуулан ажиллуулж болно. Тэгсэн хэдий боловч ийнхүү зарим тодорхой нөхцөл байдалд эрх зүйн ерөнхий хэм хэмжээг мөн захиргааны байгууллагууд ч тогтоож болдог юм.⁸

Эрх зүйн зарчмыг эрх зүйн зүй тогтолт шинжээр нь 1) Хууль ёсны зарчим, 2) Жам ёсны зарчим гэж ангилсан⁹ бол эрх зүйн зарчмыг эрх зүйн эх сурвалж болох ач холбогдлоор нь эрх зүйн нийтлэг (жам ёсны) зарчим ба позитив эрх зүйн зарчим гэж хоёр ангилан¹⁰ авч үзжээ.

Зарчмыг үндсэн (суурь) ба дэд (тусгай) зарчим гэж ангилдаг. Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг Үндсэн хуулиар бэхжүүлсэн байдаг.¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”¹² гэж заасан нь хууль тогтоомжид агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санааны хувьд бэхжин нийтлэг эх сурвалж болж байгаа зарчмын талаарх онолын ойлголт юм.

Ардчилсан ёс - аль нэг хүний буюу хэсэг бүлэг этгээдийн ард түмний нэр барьж дур зоргоороо авирлах эмх журамгүй явдал огт биш, ард түмний олонхийн санал зоригийг хэрэгжүүлэх нарийн дэг журам юм.

Шударга ёс – зөвийг эрхэмлэн дээдэлж, энэрэн хайрлаж, хөхүүлэн дэмжих, бурууг жигшин зэвүүцэж, зэмлэн цээрлүүлэх талаар хүн төрөлхтний харилцаанд тогтсон үнэт

⁸ Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. УБ., 2013. 119 дэх тал.

⁹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010. 66 дахь тал.

¹⁰ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010. 113 дахь тал.

¹¹ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 84 дэх тал.

¹² Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны дугаар 1-д нийтлэгдсэн.

зүйлүүдийн нэг мөн.

Хууль дээдлэх зарчим нь “хуульд нийцэх”, “хуульд үндэслэх” гэсэн хоёр элементээс бүрдэнэ.¹³ Засаг төрийн байгууллага, албан тушаалтан хууль дээдлэх зарчмыг хэрхэн баримталж, гаргасан хууль, зарлиг, тогтоол, албаны үйлдэл, явдал нь Үндсэн хуульд хэрхэн нийцэж байгааг хянах эрх иргэдэд, иргэний нийгэмд байдаг.¹⁴

Хууль дээдлэх зарчим нь төрийн засаглах эрх мэдлийг хуваарилах ёсыг хэрэгжүүлэхэд удирдамж болдог. Төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчим:

1. Тухайн орны хууль тогтоомжийн тогтолцоонд Үндсэн хуулийг дээдлэх;

2.Төр болон иргэн хоёр харилцан хариуцлага хүлээх;

3.Хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хүндэтгэж түүний баталгааны үндсэн механизмыг тогтоосон байх;

4.Иргэд болон бусад субьектын эрх ашгийг хууль бусаар хохироох аливаа дур зоргоос шүүхийн журмаар хамгаалах;

5.Дотоодын хууль тогтоомжийн заалтууд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй зохицсон байх;

6.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах нөхцөлөөр хангагдах; төрийн үйл ажиллагаанд хуулийг дээдлэх зарчим бол эрх зүйт төрийг бүрдүүлэх нэг үндсэн нөхцөл бөгөөд төрийн дээр хуулийн засаглал тогтоох явдал юм.¹⁵

Хууль дээдлэх зарчим нь эрх зүйн дараах зарчмуудын хууль зүйн үндэс болдог.

а)Захиргаа хууль ёсны байх зарчим;

б)Эрх зүйн баталгаат байдал буюу тодорхой байх зарчим;

с)Харьцангуй байх зарчим;

д)Төрийн эрх мэдлийг гагцхүү төрөөс хэрэгжүүлж, шүүх хараат бусаар ажиллах зарчим.¹⁶

Эрх зүйн зарчим нь харьцангуй бие даасан шинжтэй бөгөөд тусгай элементүүдээс бүрддэг. Үүнд анхны норматив шинжтэй удирдлага болгох зарчмыг ойлгох хэрэгтэй. Энэ нь нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн чиг хандлага болно. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”¹⁷ гэж заасан нь шударгаар биелүүлэх зарчим юм.

Эрх зүйн зарчим нь эрх зүйт төр, төрийн эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны үндэс болдог.¹⁸ Эрх зүйн зарчим нь тодорхой суурь үзэл санаа, зорилготой байдгаараа онцлог. Тэдгээр нь шинжлэх ухааны болон практик туршилтаар томъёологдсон байдаг. Энэ хүрээнд эрх зүйн зарчим нь, эрх зүйн ухамсрын зарчмуудтай хамт хууль зүйн шинжлэх ухааны зорилгын тэргүүлэх эгнээнд багтдаг. Хууль зүйн олон янзын үзэл санаа зорилго нь зөвхөн эрх зүйн акт эсвэл эрх зүйн хэлбэрт хэлбэржсэнээр эрх зүйн зарчим болдог.

Эрх зүйн тогтолцоонд эрх зүйн зарчим нь хууль зүйн үзэл санаа болон мэргэжлийн эрх зүйн ухамсраас ялгаатай нь үргэлж заавал биелэгдэх шинжтэй байдагт оршино.

Эрх зүйн зарчим нь бүтэц зохион байгуулалтын хувьд нарийн, олгоход бэрхтэй бичигдсэн байдаг бөгөөд тэр нь олон янзын хууль зүйн шаардлагаас бүрдэхээс гадна тэдгээр нь хоорондоо нягт уялдаа холбоотойгоор үйлчилдэг.

Захиргааны эрх зүйн төрөл хэсэгт хамаарах зарчмуудыг “захирах захирагдах ёс, төрийн албанд мэргэшсэн тогтвортой байх, хариуцлагад татагдагчийн эрхийг хамгаалах, ил тод байдал нууцлалыг хослох, хууль

¹³ Г.Банзрагч. Эдийн засгийн захиргааны эрх зүй. УБ., 2013. 56 дахь тал.

¹⁴ Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 462 дахь тал.

¹⁵ Г.Совд., ба бусад. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000. 26-29 дэх тал.

¹⁶ Ч.Өнөрбаяр. Үндсэн хуульд ёсны хөгжил, түүний чиг хандлага. УБ., 2014. 53-57 дахь тал.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны дугаар 1-д нийтлэгдсэн.

¹⁸ Б.Минжүүрдорж. Эрх зүйн онол. УБ., 2010. 14 дэх тал.



Хууль сахиулахуй

ёсны байх, гэм буруугийн презумцийн зарчим” гэж нэрлэсэн байна.¹⁹ Төрийн албаны мэргэшсэн байх чанарыг хангах гол арга хэрэгсэл нь боловсон хүчний сайн бодлого буюу тэдгээрийг бэлтгэх, шилж сонгох, байршуулах, дэвшүүлэх “зөв” тогтолцоо байх явдал юм.²⁰

Төрийн албаны зарчим

Хувь хүртэх тогтолцоо буюу Спойл (spoil principle) зарчим нь Төрийн удирдлагын мэргэжлийн боловсон хүчин тогтворгүй, улс төрийн сонгуулиар удирдлагын бүх бүтэц өөрчлөгдөж, төр захиргааны багийг ажлын аппараттай нь хамт цоо шинээр бүрдүүлдэг явдал юм.

Гавьяаны тогтолцоо буюу Мерит (merit principle) зарчим нь Төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах ажиллагаа хувийн болон улс төрийн үзэмжээс илүү хувь хүний мэргэшил, ур чадварт үндэслэсэн байх зарчим юм. Сонгон шалгаруулах албан тушаалд дэвшүүлэх ажиллагаа ажилтан бүрийн ажлын гүйцэтгэл, мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг бодитойгоор хэмжихийн (гол төлөв нээлттэй, өрсөлдөөнт шалгаруулалтын журмаар) зэрэгцээ төрийн албаны зөвлөл нь албан тушаалын ангилал, цалин хөлсний нэгдсэн сүлжээг боловсруулж мөрдүүлдэг, улс төрийн нөлөөллөөс ангид, боловсон хүчний удирдлагын мэргэшсэн тогтолцоо болж төлөвшсөн байдал.²¹ “Мерит тогтолцоо” гэдэг нь зарчмыг хэрэгжүүлэх бүх нөхцөлийг бүрдүүлсэн улс төр, эрх зүй, бүтэц зохион байгуулалтын нийлбэр цогц юм. Энэ тогтолцооны гол онцлог нь төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай, мэргэжлийн өндөр түвшинд ажиллах баталгааг хангадагт оршино.²² Энэхүү баталгааг төр Үндсэн хуульд нийцүүлэн хууль батлан хэрэгжүүлэх зарчмаар хангана.

¹⁹ Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүйн ба захиргааны процессын ажиллагаа. УБ., 2001. 19 дэх тал.

²⁰ Ж.Сүхбаатар. Захиргааны эрх зүй. УБ., 2002. 115 дахь тал.

²¹ Ц.Даваадулам. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010. 63 дахь тал.

²² Х.Наранбаатар. Төрийн алба. УБ., 2010. 7 дахь тал.

Иргэний эрх, ашиг сонирхол, хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч түүнийг сахин мөрдөж, хамгаалах нь захиргааны эрх зүйн гол зарчим юм. Өөрөөр хэлбэл, аливаа захиргааны үйл ажиллагаа юуны түрүүнд хувь хүн болон нийгмийн амьдрал дахь түүний эрх ашгийг дээдлэн үзэх зарчимд суурилдаг.²³ Захиргааны үйл ажиллагааны зарчим - Захиргаа нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн үйл ажиллагаандаа хамаарсан олон янзын зарчмыг баримталдаг.²⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон Төрийн албаны (2002) тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараах зарчмыг баримтална: 4.2.1. захирах, захирагдах ёс; 4.2.2. ил тод байх; 4.2.3. ард түмэнд үйлчлэх; 4.2.4. иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх; 4.2.5. төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх; 4.2.6. төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах; 4.2.7. хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах” заасан зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болно.

Эрх зүйн зарчимд үндэслэн тодорхой тохиолдолд шийдвэрлэх эрх олгож буй нь хуульд зааснаар хууль тогтоогч өөрийн эрх мэдлийг шилжүүлж буй гэж ойлгож болох боловч нөгөө талаас нийгэмд шударга ёсыг авчрах арга хэрэгсэл гэдэг утгаараа хуульд шууд заагаагүй байсан ч эрх зүйн зарчимд үндэслэх (хэрэв хуульд тусгагдаагүй тийм зарчим байвал) боломж нээлттэй байдгийг харуулдаг.²⁵

Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж

²³ Ш.Цогтоо. Нийтийн захиргаа: Удирдлага, эрх зүй. УБ., 2011. 53 дахь тал.

²⁴ П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2008. 30 дахь тал.

²⁵ Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2014. 97 дахь тал.

буй бүх байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагаандаа удирдлага болгон баримтлах гол үзэл санааг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэнэ.²⁶

Төрийн албаны (2002) тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-т “Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна: 7.1.1 ... шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал; 7.1.3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв, бусад туслах нэгжийн... удирдах ба гүйцэтгэх албан тушаал;” хуулиар хамаарч байгаа нь шүүхийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны үйл ажиллагааг гүйцэтгэж буйг илтгэж байна. Энэ ч хүрээгээрээ Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн 3.1.-д Төрийн захиргааны албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан зарчмыг баримтлана: шударга ёсны (хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхолын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах); хууль дээдлэх (төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээлэн сахих); тэгш байдал (бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах); хариуцлага хүлээх (албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага

хүлээх); олон нийтэд үйлчлэх (төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах)”²⁷ гэж заажээ. Төрийн үйл ажиллагаанд шударга ёсны зарчим нь хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх үндсэн бааз нь болохын хамт энэрэнгүй ёс, эрс шийдэмгий, гарцаагүй хариуцлагын тухай тогтолцоог бүрдүүлнэ.

Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т “Захиргааны үйл ажиллагаанд дараах тусгай зарчмыг баримтлана: 4.2.1. хуульд үндэслэх; 4.2.2. шуурхай, тасралтгүй байх; 4.2.3. хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх; 4.2.4. үр нөлөөтэй байх; 4.2.5. зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх; 4.2.6. бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах; 4.2.7. ашиг сонирхолын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах, татгалзан гаргах боломжийг хангах; 4.2.8. хууль ёсны итгэлийг хамгаалах;”²⁸ (2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө) гэж захиргааны үйл ажиллагааны зарчмыг хуульчилсан байна.

Төрийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны уялдаа холбоог тогтоох, тэдгээрээс хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх явцад төрийн байгууллага, албан тушаалтнаас үйл ажиллагаандаа мөрдлөг болгож буй хамгийн гол үзэл санааны нийлбэр цогцыг төрийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндсэн зарчим гэнэ.²⁹

Төрийн үйл ажиллагааны зарчим нь

²⁷ Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2011.6-7 дахь тал.

²⁸ Захиргааны ерөнхий хууль. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2015 оны дугаар 28-д нийтлэгдсэн.

²⁹ Б.Нармандах. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2005. 165 дахь тал.

²⁶ Д.Лүндээжанцан., Ч.Энхбаатар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000. 110 дахь тал.



Хууль сахиулахуй



төрийн зорилготой салшгүй холбоотой. Энэ нь Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан, эрх зүйт төрийг байгуулах төрийн зорилгод хүрэх арга зам буюу арга хэрэгсэл нь болно. Өөрөөр хэлбэл, төрийн үйл ажиллагааны зарчмаар түүний зорилго илэрч байдаг. Төрийн зорилго нь үзэл баримтлалын шинжтэй байдаг бол төрийн үйл ажиллагааны зарчим нь заавал мөрдөх шаардлага гэж болно.³⁰ Төрийн үйл ажиллагааны зарчмын энэхүү шинж нь төрийн эрх мэдэл хуваарилах онол ёсоор бэхэжсэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагааг нарийвчлан илэрхийлнэ

Монгол Улсад нийт 568 хууль үйлчилж байгаагаас 152 хуульд зарчмын хэм хэмжээ тусгайлан хуульчлагдсан байна.

II. ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Шүүх эрх мэдэл засгийн гурван салааны нэгийн хувьд биеэ даасан байна; шүүгч нь түүний бүрэлдэхүүний хувьд бусдаас хараат бус байна; энэ үндсэн дээр уул эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ зөвхөн хуульд захирагдана гэсэн нэг нь нөгөөгөө нөхөн дэмжсэн гурван зарчмыг томьёолсон гэж ойлгож хөгжүүлэх нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн гол үзэл баримтлал гэж болно.³¹ Энэ Үндсэн хуулийн үзэл баримтлал нь Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүх байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг баталгаажуулан дэмжих зорилгыг агуулж байна.

НҮБ-с 1985 онд Милан хотод баталсан “Шүүхийн байгууллагын хараат бус байдлын үндсэн зарчмууд”-н Шүүхийн байгууллагын хараат бус байдал: 1 дүгээр зүйл. Шүүхийн байгууллагын хараат бус байдлыг төр баталгаажуулж

өөрийн орны үндсэн хууль, бусад хуульд бататган тунхаглана; мэргэжил, шилэн шалгаруулалт ба бэлтгэл: 10 дугаар зүйл. ...шүүгчийг хууль бус сэдэлтээр томилох явдал гаргуулахгүй байх баталгааг хангасан байх ёстой; 14 дүгээр зүйл. Тухайн шүүхэд хэргийг ажиллаж байгаа шүүгчдэд хуваарилах нь шүүхийн захиргааны дотоод ажил мөн.³² Шүүх байгууллагын хараат бус байдлын дээрх Олон улсын эрх зүйн зарчмын агуулга нь тус зарчимд нийлүүлэн төр хууль тогтоох эрх мэдлээр уламжлан эрх зүйн үндсийг баталгаажуулах тухай юм.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим гэдэг нь шүүхийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болох шүүн таслах ажиллагаандаа удирдлага болгохоор хуульчилсан Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал юм.³³

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана”; Шүүхийн ерөнхий зөвлөл бол засаг төрөөс шүүхэд үзүүлэх нийтийн үйлчилгээг эрхэлсэн, биеэ даасан гүйцэтгэх байгууллага мөн.³⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4-т “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” гэж заасныг Шүүхийн тухай (1993) хуулийн 32 дугаар зүйл, Шүүхийн тухай (2002) хуулийн 60 дугаар зүйлд (Үндсэн хуульд зааснаар Ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий хамтын удирдлагын, орон тооны бус байгууллага мөн;

³⁰ Г.Банзрагч. Эдийн засгийн захиргааны эрх зүй. УБ., 2013. 52 дахь тал.

³¹ Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. УБ., 2010. 72 дахь тал.

³² Хүний эрх: Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996. 179-184 дэх тал.

³³ Д.Солонго., ба бусад. Үндсэн хуулийн эрх зүй. Гарын авлага. УБ., 2007. 179 дэх тал.

34 Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 329 дэх тал.



Хууль сахиулахуй

Ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангах үүргийг хэрэгжүүлнэ); Шүүхийн мэргэжлийн удирдлагыг Шүүхийн тухай (2002) хуулийн 15 дугаар зүйлийн 4-т “Шүүхийн мэргэжлийн удирдлага нь хуулийг тайлбарлах, сургалт явуулах, шүүхийн практикийг нэгтгэн судалж, зөвлөмж гаргах хэлбэртэй байна” гэж хуульчилсан нь шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг мэргэжлийн удирдлагад нэгтгэн удирдан зохион байгуулж байсныг илтгэж байна.

Шүүхийн бие даасан байдлыг хангахын тулд засаг захиргааны үйлчилгээг “Шүүхийн ерөнхий зөвлөл” байгуулан эхлүүлэх, бүх шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлэх хийгээд шүүхийн үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах үүрэгтэй байх зэрэг шинэ механизм, зарчим тогтоож өгсөн.³⁵

Шүүхийн тухай (2012) хуулийн 6.5-д “Шүүх өөрийн захиргаатай байх ба түүний чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тамгын газар хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна, мөн хуулийн 7.1-д Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж шинэчлэн баталсан хуулиудын нэг бүлэгт хуульчилснаар Шүүхийн ерөнхий зөвлөл бие даасан, хараат бусаар шүүх эрх мэдлийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн үндсэн зарчмыг бэхжүүлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно”³⁶ гэж заасны дагуу Шүүхийн

захиргааны тухай бие даасан хууль анх удаа 2012 онд батлагдсан. Энэ хууль нь Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс, шүүхийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, материал техникийн хангамж, мэдээллээр үйлчлэх чиг үүрэгтэй байгууллагын статустай болгох үзэл баримтлалыг удирдлага болгон батлагдсан байна.³⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл бол Үндсэн хуулиар үндсийг нь тодорхойлсон зорилго чиг үүрэг бүхий харьцангуй биеэ даасан байгууллага мөн. Өөрөөр хэлбэл, шүүх шиг хараат бус үндсэн дээр биеэ даасан биш боловч, шүүгч шүүхийн үйл ажиллагааны онцлог байдал, үндсэн зарчмыг төрөөс хангах баталгааг бүрдүүлэн бэхжүүлэх төрийн үүргийг бие дааж үндсэн ажил болгон эрхэлсэн зохион байгуулалт хангалт, үйлчилгээний тусгай байгууллага мөн.³⁸ Шүүхийн захиргааны тухай (2012) хуулийн 3 дугаар зүйл. “Шүүхийн захиргаа: 3.1. Шүүхийн захиргаа нь Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “Ерөнхий зөвлөл” гэх), түүний ажлын алба, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв болон бусад туслах нэгжээс бүрдэнэ; 3.2. Шүүхийн захиргаа нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй байна” гэж; мөн 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 3-т “Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу хууль тогтоох, гэмт хэрэг, эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг

³⁵ Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). УБ., 2010. 29 дэх тал.

³⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1992 оны дугаар 1-д нийтлэгдсэн.

³⁷ Шүүхийн захиргааны байгууллагын бие даасан загвар, харьцуулсан тойм судалгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын төв. УБ., 2013. 3 дахь тал.

³⁸ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. II дэвтэр. УБ., 2004. 151-152 дахь тал.

үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллагад тооцно” гэж хуульчилжээ.

Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн (2013) тунхаглалын 4-т “Санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, захиргааны бие даасан байдал нь бие даасан, хараат бус шүүхийн зайлшгүй хамгаалалт мөн”; 5-д “Шүүхийн хараат бус байдлын хамгаалалт нь шүүхийн төсөв, тэдний ажлын нөхцөл байдалтай холбоотой бүхий л асуудлыг авч үзэх, засгийн газарт санал, зөвлөмж гаргах эрх бүхий шүүхийн зөвлөл эсхүл түүнтэй адил бие даасан байгууллагаас зохих ёсоор чиг үүргээ хэрэгжүүлснээр хэрэгжих боломжтой”³⁹.

Шүүхийн шүүн таслах ажиллагааны мэргэжлийн удирдлага, захиргааны удирдлага хоёрыг заагласан. Өөрөөр хэлбэл, шүүхийн процессын удирдлагын хяналтыг Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн толгойлсон давж заалдах болон хяналтын шатны танхимууд, улмаар Дээд шүүхийн (шүүгчдийн) хурал, зохион байгуулалтын удирдлагыг буюу үйлчилгээг Шүүхийн ерөнхий зөвлөл болон зохих шүүхийн тамгын газар, хэлтэс, алба, төлөөлөгч хэрэгжүүлнэ.⁴⁰ Шүүхийн захиргааны удирдлага гэсэн томъёололоор бус шүүх нь захиргааны бүтцийн нэгжээр шүүн таслах ажиллагаанд үл хамаарах өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх захиргааны байгууллагатай, түүнийг үйл ажиллагааны зарчмыг Шүүхийн захиргааны тухай (2012) хуулийн 4 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчим 4.1.1-д бие даасан, хараат бус байх - шүүхийн захиргаа бол шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг бүтэц юм, Шүүхийн

захиргааны бүрэлдэхүүний дийлэнхийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчид болон хууль зүйн салбарын нэр хүндтэй эрдэмтдээс бүрдүүлсэн улс төрөөс ангид мэргэжлийн байгууллага байх нь чухал юм;⁴¹ 4.1.2-т шүүн таслах ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглох - шүүхийн байгууллагын өөрчлөлт, шинэчлэлийн стратеги бодлоготой уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг ашиглан хамгийн чадварлаг, шударга хуульчдаас шүүгчдийг бүрдүүлэх, тасралтгүй сургаж дадлагажуулах замаар шүүгчийг итгэл хүндэтгэл хүлээсэн, улам чадварлаг болгон хөгжүүлэх, шүүхийн удирдлага менежментийн шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, мэдрэмжтэй, хариуцлагатай, бүтээмжтэй байх чадварыг хөгжүүлэхийн төлөө ажиллана гэсэн үг;⁴² 4.1.3-т мэргэшсэн, тогтвортой байх - шүүхийн шийдвэрийн чанар нь шүүгчийн болон шүүхийн бусад албан хаагчийн мэргэшлийн ур чадвартай салшгүй холбоотой;⁴³ 4.1.4-т шүүхийн үйл ажиллагаа шуурхай, хүртээмжтэй байх гэж хуульчилж өгсөн байна.

Шүүхийн хараат бус байх субъектыг эрх бүхий байгууллага, улс төрийн хүчин, албан тушаалтны хүрээнд ойлгох бөгөөд харин шүүхүүдээс хариуцлага хүлээх субъект нь нийгэм өөрөө юм. Иймд шүүхийн хараат бус байдал ба шүүхийн нийгмийн хариуцлага хоорондоо харшлахгүй төдийгүй харин ч нэгэн зоосны хоёр тал мөн. Гагцхүү энэ хоёр зарчмыг шүүхийн үйл ажиллагаанд тэнцвэртэй хэрэгжүүлэх нь хамгаас чухал байдаг.⁴⁴

Үндэсний эрх зүйн тогтолцооны хувьд эрх зүйн зарчим нь ихэвчлэн

⁴¹ Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь (Бодлогын тойм судалгаа). УБ., 2010. 36, 41 дэх тал.

⁴² Н.Эрдэнэцогт. Монгол Улс ын Үндсэн хуулийн дөчин долдугаар, дөчин наймдугаар, дөчин есдүгээр зүйлийн онолын тайлбар. // Эргэцүүлэл. УБ., 2012. №40. 803-807 дахь тал.

⁴³ Енс Ёоханнэс Дэппэ., Иммануэл Гэбхардт. Монгол Улс ын эрх зүйн болоод шүүх эрх мэдлийн шинэтгэл-эргэн харахад. // Хууль дээдлэх ёс. УБ., 2011. №35. 59 дэх тал.

⁴⁴ Ч.Энхбаатар. Шүүхийн хараат бус байдал ба нийгмийн хариуцлага.// Шихихутуг. Эрх зүйн шинжлэх ухааны онол арга зүйн сэтгүүл. УБ., №8. 2003. 13-14 дэх тал.

³⁹ Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн (2013) тунхаглал. Шүүх эрх мэдэл. УБ., 2015. №4. 53-55 дахь тал.

⁴⁰ Ж.Амарсанаа., ба бусад. Шүүх эрх мэдлийн шинэтгэл. УБ., 2012. 49 дэх тал.



Үндсэн хуульд бэхэжсэн түүхтэй. Тухайлбал: ОХУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 19-д “Бүгд хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд “Хэний ч эрх чөлөөг дур мэдэн хязгаарлахгүй. Шүүх эрх мэдэл нь хувь хүний эрх чөлөөг хадгалагчийн хувьд хуульд заасан нөхцөлийн дагуу энэ зарчмыг баримтлах явдлыг хангана”;

ХБНГУ-ын Үндсэн хуулиар муж улсууд нь өөрийн шүүхийн тогтолцоог бий болгон, хэргийг хянан шийдвэрлэх журмыг тогтоохоос гадна шүүхийн төвлөрлийг сааруулах зарчмын нэг илрэл нь тухайн муж улс өөрийн нутаг дэвсгэрийн шүүхийг боловсон хүчнээр хангах, үйл ажиллагааг нь хэвийн байлгахтай холбогдсон асуудлыг шийдэх эрхтэй;⁴⁵

Шведийн Үндсэн хуулиар шүүх, шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулж, Засгийн газар, Парламентийн зүгээс ямар нэгэн байдлаар шүүхийн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцож, хэрэг маргаан шийдвэрлэх үйл ажиллагаанд нөлөөлөх явдлыг хориглосон. 1975 онд шүүхийн хараат бус байдал, шүүхийн захиргаа, менежмент, төсөв, санхүүгийн асуудлыг хариуцсан тусгай зорилго бүхий бие даасан захиргааны байгууллага болох Шүүхийн зөвлөлийг байгуулсан байна;

46

Данийн Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд “шүүхийн захиргаа нь гүйцэтгэх байгууллагын эрх хэмжээнд хамаарна” хэмээн заасан хэдий ч 1999 онд Шүүхийн захиргааны бие даасан байгууллага шүүхийн зөвлөлийг байгуулсан. Энэхүү байгууллага нь шүүхийн байгууллагуудын менежмент, бүх төрлийн менежмент, сургалт, хүний нөөц, байр, зөвлөгөө мэдээлэл, суртчилгаа зэрэг өдөр тутмын үйл

ажиллагааг хариуцан зохион байгуулдаг Хууль зүйн яамны бүтцэд хамаардаг шүүхийн захиргааны байгууллага юм;⁴⁷

Дээрх улсуудын Үндсэн хуулийн үзэл баримтлал нь шүүхийн захиргааны байгууллага байгуулах хууль зүйн үндэслэл болсон бөгөөд шүүхийн захиргааны байгууллага нь зохион байгуулан эрхлэх ажил үүргийнхээ хүрээнд шүүх байгууллагын өдөр тутмын хэвийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхдээ бие даасан, хараат бус байх зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилладаг гэж тодорхойлж болно. Шүүхийн захиргааны үйл ажиллагааны нэрлэгдсэн зарчмын хувьд хуулиар баталгааждаг, ёс суртахууны болон заншлын хэм хэмжээ, зарчмыг улс орнуудын уламжлал, соёл, хөгжлийн чиг хандлагаар илэрхийлнэ.

Шүүх эрх мэдлийн процессийн эрх зүйн зарчим – ...төрийн зохих байгууллагын үйл ажиллагааны хууль ёсны, үр нөлөөтэй байдал, гаргаж буй шийдвэрийнх нь үндэслэлийг хангана. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад органик хуульд шүүхийн зохион байгуулалт, шүүх эрх мэдэлд хамаарах түгээмэл зарчмыг хуульчилсан. Эдгээр зарчим нь шүүх эрх мэдлийн процессийн салбар бүрт нийтлэг байна. Үүнийг тодруулбал:

1. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2. Шүүгч хараат бус байж зөвхөн хуульд захирагдана.

3. Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

4. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна.

5. Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна.

6. Гэрчлэх эрх үүргийг хамгаалах зарчим.

7. Шүүх эрх мэдлийн процесс хугацаатай байх, өөрөөр хэлбэл процессийн үйлдлийн хугацааг нарийн тооцож, мөрдөх зарчим.

⁴⁷ Мөн тэнд. 21 дэх тал.

⁴⁵ Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2014. 127 дахь тал.

⁴⁶ Шүүхийн захиргааны байгууллагын бие даасан загвар, харьцуулсан тойм судалгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын төв. УБ., 2013. 19 дэх тал.

8.Процессийн эрх зүйг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх зарчим.

9.Шүүх эрх мэдлийн процесст амаар болон бичгээр хослох зарчим.

10.Нийтийн ашиг сонирхлын үүднээс төрийн байгууллага албан тушаалтнаас шаардлагатай үед процессийн арга хэмжээ хэрэглэх зарчмыг дурдаж болно.⁴⁸

Шүүхийн захиргааны онцлог нь шүүн таслах ажиллагаанд үл оролцох зарчим юм. Өөрөөр хэлбэл, шүүгчийн шүүн таслах ажиллагааны хүрээнд ямар нэг захиран тушаах чиг үүрэг хэрэгжүүлдэггүй, хязгаарлагдмал захиргаа юм.

АНУ-ын “Муж улсуудын шүүхийн үндэсний төв”-өөс боловсруулсан баримт бичигт шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг: 1) Засаглалын – шүүхийн захиргааны бүтэц, зохион байгуулалт нь ухаалаг бөгөөд оновчтой, бүрэлдэхүүн нь мэргэшсэн, чадварлаг, шүүхийн бүх төрлийн нөөцийн бодлогыг зөв удирдах; 2) Хэргийн хөдөлгөөнийг удирдах – процесс ажиллагааны сахилгыг сахиулах, хяналт тавих механизмыг бүрдүүлэх, хэрэг, маргааныг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай шийдвэрлэх арга замыг боловсруулах; 3) Төсвийн эрхийн – шүүхийн төсвийн төслийг хууль тогтоох эрх мэдлийн байгууллага шүүхийн захиргааны байгууллагын өргөн мэдүүлснээр хэлэлцэх, төсөв нь шүүхийн үйлчилгээг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хүртээмжтэй түгээх технологийн дэвшлийг хангахуйц байх, зарцуулалт нь ухаалаг зөв, шударга байх гэсэн гурван бүлэг суурь зарчмын хүрээнд тодорхойлжээ.⁴⁹ Эдгээр бүлэг зарчмыг шүүхийн захиргааны байгууллага үйл ажиллагаандаа удирдлага болгосноор бүтцийн, нэгжийн ажил үүргийн

⁴⁸ Ц.Амарсайхан., ба бусад. Процессийн эрх зүй: онол, туршлага. УБ., 2014. 27-28 дахь тал.

⁴⁹ Н.Лүндэндорж. Монгол Улс дахь шүүхийн захиргаа, түүний төлөвшил. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд. Олон улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2014. 7-8 дахь тал.

хуваарийн давхардлаас зайлсхийх боломжтой юм.

Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал нь шүүхийн байгууллагын тогтолцоо, юуны өмнө түүний бүрэлдэхүүн болох шүүгчдийн хараат бус байдал, бүтцийн нэгж болох шүүх тус бүрийн бие даасан байдал болон үйл ажиллагааны үндсэн зарчим, тэдгээрийг хангах баталгаагаар тодорхойлогдож байна.⁵⁰ Энэхүү тодорхойлолтын агуулгаар хуулиар зохион байгуулалт, үйл ажиллагааны журмаа тогтоосны хувьд бие даасан хэв шинж нь баталгаажсан ч хараат бус байх нь хязгаарлагдмал хүрээнд тодорхойлогдоно. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч нэгдмэл тогтолцоо бүхий шүүх (3.1.1 “шүүх” гэж Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг) байгууллагын эрх үүргийн нэгдлийн хүрээнд эрхлэн гүйцэтгэх ажлын тасралтгүй үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах нь шүүхийн ерөнхий зөвлөлийн мэргэшсэн, тогтвортой байх зарчимд суурилна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дүрмийн 2.1-д Ажлын алба үйл ажиллагаандаа Шүүхийн захиргааны тухай хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчмыг удирдлага болгоно; Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 42 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 1.3-т Тамгын газар үйл ажиллагаандаа Шүүхийн захиргааны тухай хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндсэн зарчмыг удирдлага болгож баримтлана гэжээ.

Гэвч шүүн таслах ажиллагааны

⁵⁰ Ж.Амарсанаа., ба бусад. Шүүх эрх мэдлийн шинэтгэл. УБ., 2012. 15 дахь тал.



Хууль сахиулахуй

талаар өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар, шүүхийн нэрийн өмнөөс хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүн таслах ажиллагааг сайжруулах, боловсронгуй болгох талаар мэдэгдэл хийх, шүүн таслах ажиллагаанд үнэлэлт өгөх, мөн эрх зүйн хэм хэмжээг тогтоох болон хууль хэрэглэх журмаар шүүх, шүүгчийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2013 оны 12 дугаар сард "өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэхийг хориглох" хуулийн заалтыг зөрчиж гаргасан шийдвэрээр Мэргэшлийн хороо, Сахилгын хорооны шийдвэр гараагүй байхад нэр бүхий шүүгчдийг сэлгэн ажиллуулсан практик, мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 09 дүгээр тогтоолоор баталсан Шүүгчид чөлөө олгох журам нь шүүгчийн хараат бус байх Үндсэн хуулийн зарчим, шүүн таслах ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглох Шүүхийн захиргааны тухай хуулийн шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тус тус зөрчсөн талаар дурдаж болох юм. Хуулийн хэм хэмжээг захиргааны байгууллагаас хуульчилсан актаар зөрчих нөхцөлийг хаах, хяналт тавих, шүүгч нарыг оролцуулсан мониторинг хийж байх механизмыг бүрдүүлэх шаардлагатай.

Шүүхийн захиргааны бараг бүх чиг үүрэг, бүрэн эрх Шүүхийн ерөнхий зөвлөлд төвлөрсөн бөгөөд ийм хүчтэй шүүхийн зөвлөл олон жил ажиллавал шүүгчийн хараат бус байдалд халдах, хариуцлагагүй байдлыг дэвэргэх эрсдэлтэйг бусад улсын туршлага харуулдаг.⁵¹

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 111 дүгээр тогтоолоор Шүүхийн шинэ менежмент -ийн хөтөлбөр баталсан. Тус хөтөлбөрийн зорилго нь шүүхийн үйлчилгээг үр нөлөөтэй, хүртээмжтэй,

хариуцлагатай хэрэгжүүлэхийц чадварлаг захиргаа, дэд бүтцийг бүрдүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд: Чадварлаг захиргаа - Ухаалаг бүтэц, ойлгомжтой дүрэм, журам, заавар, мэдээллийн найдвартай тогтолцоо бүхий, нээлттэй, ил тод олон нийтийн хяналтыг хангасан, судалгаанд суурилсан, хүнд суртал, авлигагүй, инноваци, шинэ санаачлагыг дэмжсэн шүүхийн захиргааг төлөвшүүлэх зорилт дэвшүүлсэн нь шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх тодорхой алхам болсон байна.

САНАЛ

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах тухай зарчмыг хэлбэрэлтгүй үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй удирдлага болгох;

2. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хууль ёсны, ёс суртахууны зарчмыг тодорхойлж өгөх.

ДҮГНЭЛТ

Шүүх эрх мэдлийн шинэтгэл 1992 оны Үндсэн хууль батлагдснаас хойшх хугацаанд тасралтгүй үргэлжилж байгаа бөгөөд энэхүү шинэтгэлийн үр дүнд шүүхийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүргийг тодорхойлсон.

Шүүхийн захиргааны байгууллага нь шүүхийн удирдлагын чиг үүрэгтэй байгууллага бус зөвхөн шүүх байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хамтын удирдлагын байгууллага юм. Энэ утгаар шүүхийн захиргааны бие даасан, хараат бус байх зарчмыг хуулиар баталгаажуулсан нь шүүхийн мэргэжлийн удирдлага, шүүхийн захиргааны удирдлага гэсэн хоёр үндсэн ойлголтыг тусгайлан судлах, мөн эдгээрийн үйл ажиллагааны үндсэн зорилго, зарчмын хэрэгжилтийг ханган, үйл ажиллагаандаа удирдлага болгосноор захиргаа гэсэн нэрийн

⁵¹ Шүүхийн захиргааны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. Бодлогын судалгаа. Нээлттэй нийгэм форум. №19



дор удирдах эрх эдлэх бус шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий Үндсэн хуулийн байгууллага болохын хувьд үйл ажиллагаандаа Үндсэн хууль дахь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг дүрэм, журамд дурдах бус агуулгыг өргөтгөн удирдлага болгож хэрэгжүүлж байх учиртай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Ном, сурах бичиг

1.Ж.Амарсанаа., ба бусад. Шүүх эрх мэдлийн шинэтгэл. УБ., 2012.

2.Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. УБ., 2014.

3.Ц.Амарсайхан., ба бусад. Процессийн эрх зүй: онол, туршлага. УБ., 2014.

4.Г.Банзрагч. Эдийн засгийн захиргааны эрх зүй. УБ., 2013.

5.Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. Мон судар хэвлэлийн газар. УБ., 2011.

6.Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010.

7.Ред Ц.Балхаажав., ба бусад. Философийн толь. УБ., 1990.

8.Ц.Даваадулам. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. УБ., 2010.

9.Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүйн ба захиргааны процессын ажиллагаа. УБ., 2001.

10.Жан Жак Руссо. Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд. УБ., 2015.

11.Д.Лүндээжанцан., Ч.Энхбаатар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000.

12. Б.Минжүүрдорж. Эрх зүйн онол. УБ., 2010.

13.С.Нарангэрэл., Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2011.

14.Х.Наранбаатар. Төрийн алба. УБ., 2010.

15.Б.Нармандах. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2005.

16.Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2010.

17.П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2008.

18.Ч.Өнөрбаяр. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. УБ., 2014.

19.Г.Совд., ба бусад. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000.

20.Д.Солонго., ба бусад. Үндсэн хуулийн эрх зүй. Гарын авлага. УБ., 2007.

21.Ж.Сүхбаатар. Захиргааны эрх зүй. УБ., 2002.

22.Ханнс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. УБ., 2013.

23.Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2002.

24.Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл. II дэвтэр. УБ., 2004.

25.Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008.

Хоёр. Хурлын баримт бичиг, өгүүлэл, итгэлийн эмхэтгэл

1.Енс Ёоханнэс Дэппэ., Иммануэл Гэбхардт. Монгол Улсын эрх зүйн болоод шүүх эрх мэдлийн шинэтгэл-эргэн харахад. // Хууль дээдлэх ёс. УБ., 2011. №35. 59 дэх тал.

2.Н.Лүндэндорж. Монгол улс дахь шүүхийн захиргаа, түүний төлөвшил. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд. Олон улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2014. 7-8 дахь тал

3.Н.Эрдэнэцогт. Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин долдугаар, дөчин наймдугаар, дөчин есдүгээр зүйлийн онолын тайлбар. // Эргэцүүлэл. УБ., 2012. №40. 803-807 дахь тал

4.Ч.Энхбаатар. Шүүхийн хараат бус байдал ба нийгмийн хариуцлага.// Шихихутуг. Эрх зүйн шинжлэх ухааны онол арга зүйн сэтгүүл. УБ., №8. 2003. 13-14 дэх тал.

Гурав. Судалгааны тайлан

1.Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. УБ., 2010



Хууль сахиулахуй

2. Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь (Бодлогын тойм судалгаа). УБ., 2010.

3. Шүүхийн захиргааны байгууллагын бие даасан загвар, харьцуулсан тойм судалгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн судалгаа мэдээлэлийн төв. УБ., 2013.

4. Шүүхийн захиргааны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. Бодлогын судалгаа. Нээлттэй нийгэм форум. №19. 2015.

Дөрөв. Эрх зүйн актууд

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992

2. Захиргааны ерөнхий хууль. 2015

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм (мөн түүний хавсралт болох Олон улсын шүүхийн дүрэм). 1945

4. Төрийн албаны тухай хууль. 2002

5. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн тухай эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2011

6. Хүний эрх: Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996.

7. Шүүхийн тухай хууль. 1993

8. Шүүхийн тухай хууль. 2002

9. Шүүхийн тухай хууль. 2012

10. Шүүхийн захиргааны тухай хууль. 2012

11. Шүүхийн захиргаа – I (Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл). 2014

12. Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн (2013) тунхаглал. Шүүх эрх мэдэл. УБ., 2015

**Уншиж танилцан нийтлэхийг
зөвшөөрсөн, Сэтгүүлийн
зөвлөлийн гишүүн, хууль зүйн
доктор, цагдаагийн дэд хурандаа
Ш.Ариунбилэг**